



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/142

Зуунмод

Шинжлэх ухаан, технологийн зөвлөл
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Г.Батжаргал	-Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Г.Уянга	-Засаг даргын туслах, ИХМОНХА
	Л.Эрдэнэцэцэг	-Хүмүүн цогцолбор сургуулийн ерөнхий захирал
	Д.Хунтогос	-4-р сургуулийн захирал
	Д.Хуягбаатар	-5-р сургуулийн захирал
		-Багийн Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга:	Ц.Оюунтүлхүүр	-Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2. Шинжлэх ухаан, инноваци, технологийг хөгжүүлэх чиглэлээр батлагдан гарсан төлөвлөгөөг хэрэгжүүлэн тайлан мэдээг хагас, бүтэн жилээр 2023 оны 05 дугаар сарын 23, 2023 оны 11 дүгээр сарын 24-ний дотор хүргүүлэн ажиллахыг Ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн (Д.Амартүвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.САРАНГЭРЭЛ

